

## СУДАЛГААНД ХАМРАГДСАН ИРГЭДИЙН АНХААРАЛД

2016.11.16

Улаанбаатар хот

1. Мэргэшлийн шалгалтын судалгаанд хамрагдсан, зарласан ажлын байранд тавигдах ерөнхий ба тусгай шаардлага хангах иргэдийг 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр /Баасан гараг/-ийн 09.00-17.00 цагт Хамгаалалтын хоёрдугаар газар /Хуучнаар Дотоодын цэргийн 05 дугаар цэргийн анги/-т явагдах нэгдсэн бүртгэлд бүртгэж, шалгалтад орох эрх олгоно. Иргэд өөрийн биеэр ирж бүртгүүлнэ.

Хаяг: Сонгинохайрхан дүүрэг 22 дугаар хороо, Хилчин холбоочдын гудамж

2. Бүртгэлд хамрагдах иргэд сүүлийн нэг сарын дотор эрүүл мэндийн шинжилгээ хийлгэсэн /Цус, шээс, ЭХО, Зүрхний бичлэг, ДОХ, бэлгийн замын халдварт өвчин, элэгний В, С вирус, сүрьеэгийн шинжилгээ-цээжний жижиг зураг-флюор/-ний бичиг, бүртгэлийн хураамж, өөрийн фото зураг /3x4 хэмжээний/ 2 хувийг авчирна.

3. Нэгдсэн бүртгэлд хамрагдсан иргэдэд 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр /Баасан гараг/-ийн 17.00 цагаас “Цагдаагийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс авах мэргэшлийн шалгалт авах журам” болон шалгалттай холбогдох бусад асуудлаар семинар /зааварчилга/ өгнө.

4. Шалгалтад орох иргэд өөрийн тухай үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.


5. Шалгалттай холбогдох зардлыг иргэн өөрөө хариуцана.

6. Эрүүл мэндийн үзлэгийг шалгалтын комиссоос нэгдсэн журмаар хийнэ.

7. Шалгалтад ямар нэг шалтгаанаар ирээгүй бол шалгалт өгөөгүйд тооцож хасна.


**ШАЛГАЛТЫН КОМИСС**

# ХАМГААЛАЛТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН БАЙРЛАЛ



Ч:13 "ТАХИЛТ - 5 ШАР"

 **Нийслэлийн Тээврийн Газар**  
Тээврийн Бодлого төлөвлөлтийн хэлтэс



**Хаяг: Сонгинохайрхан дүүрэг 22 дугаар хороо  
Хилчин холбоочдын гудамж**